



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

**Хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 1 дүгээр хорооны орон сууцны 2, 6 дугаар байрны хэрэглээний болон цэвэр усны босоо шугам солих ажлын гүйцэтгэл хийгдэж байгаатай холбогдуулан иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Нийтийн ариун цэврийн байгууламж”-д 2, 6 дугаар байрны иргэдийг 50% хөнгөлөлттэй үнээр үйлчлэхийг “Илч Орд” ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т үүрэг болгосугай.

2. Иргэдийг ая тухтай үйлчлүүлэх нөхцөл, боломжоор ханган ариун цэврийн эрүүл ахуйн горимыг сахиж ажиллахыг “Илч Орд” ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД